



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



МАНБА ДАЦАН
НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

СҮРЬЕЭ ӨВЧНИЙ, ЭМЧИЛГЭЭНИЙ ГАЖ НӨЛӨӨГ
УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ
ЭМ ТАНГААР ЗАСАХ
СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

2021 он

Эрхлэн гаргасан: Манба Дацан Нэгдсэн эмнэлэг

Эмхэтгэсэн:

Д.Нацагдорж – МУ-ын хүний гавьяат эмч

Ч.Дэлгэрмаа – УАУ-ы их эмч

Б.Болорзаяа – УАУ-ы их эмч

Г.Үүрийнтүяа – УАУ-ы их эмч

Хамтран ажилласан:



Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН СҮРЬЕЭ ӨВЧНИЙГ ЭМЧЛЭХ

Олон мянган жилийн тэртээ сүрьеэ өвчний оношлогоо, эмчилгээний талаарх мэдлэг, онол шүн байсныг МЭӨ үед бичигдсэн судар номонд тэмдэглэн үлдээсэн байдаг. Сүрьеэ өвчний халдварлал, тархалт, өвчлөгсдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа нь олон улсад төдийгүй Монгол улсад нэлээд анхаарууштай эрүүл мэндийн асуудал болсоор байна. Монгол улс энэ талаар олон арга хэмжээ авч явуулдаг боловч сүрьеэгийн хүндрэл, эмийн гаж нөлөө, эмэнд тэсвэртэй сүрьеэ гэх мэтчилэн олон тулгамдсан шийдвэрлэх асуудлууд байна.

Монгол улсын эрүүл мэндийн хуулинд: Орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэт аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ хэмээн заасан.

Монгол улсад сүрьеэ өвчнийг уламжлалт анагаах ухааны оношлогоо, эмчилгээг ашиглан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хууль эрх зүйн үндэслэл боломж нөхцөл байсаар байтал орчин цагийн анагаах ухаан болон уламжлалт анагаах ухааны эрүүл мэндийн байгууллагууд, төр засгийн зүгээс санаа санаачлага хоорондын хамтын ажиллагаа уялдаа холбоо дутагдалтай явж ирсэн байна.

Тиймээс Монголын уламжлалт сургалтын Манба Дацан төвөөс энэхүү асуудалд анхаарал хандуулж ирсэн бөгөөд цаашид сүрьеэ өвчний мэргэжлийн эмнэлэг, судалгааны байгууллага, эрдэмтэн, эмч судлаач хамтран ажиллаж үр дүнд хүрэх боломж байна хэмээн үзэж байна.

Сүрьеэ өвчнийг эмчлэхэд уламжлалт анагаах ухааны үр дүнтэй оношлогоо, эмчилгээг нэвтрүүлэх үр дүн, ач холбогдолтой үйл хэргийг бүтээхэд санаа санаачлага гарган ажиллаж байна.

Бидний санаачлагыг Монгол улсын эрүүл мэндийн яам, Глобал сан, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн удирдлага анхааран авч үзэж байгаа нь сашаалтай үйл хэрэг бөгөөд Монгол улсын эрүүл мэндийн салбарт нааштай эерэг сайн үр дүнг авчирна хэмээн бид үзэж байгаа.

Энэхүү ажлын хүрээнд доорх ажлуудыг хэрэгжүүлэх зорилго, зорилтууд

1. Уламжлалт анагаах ухааны үүднээс сүрьеэ өвчнийг оношлох, эмчлэх талаар эрүүл мэндийн боловсрол, мэдлэгийг эрдэмтэн мэргэд, судлаач, эмч мэргэжилтнүүд, ард иргэдэд ойлгуулан таниулах сургалт, ном товхимол гаргах, ажлуудыг дэс дараатай тогтмол зохион байгуулах.
 2. Сүрьеэ өвчнөөр өвчилсөн хүмүүсийн хүсэлтийг харгалзан уламжлалт анагаах ухааны оношлогоо, эмчилгээгээр дагнан анхан шатнаас нь эхлэн эмчилж сүрьеэ өвчний мэргэжлийн байгууллага Халдварт өвчин судлалын үндэсний төв болон бусад байгууллагтай хамтран үр дүнг тооцож судалгааны ажлуудыг явуулах.
 3. Сүрьеэгийн хүндрэл, эмийн гаж нөлөө, эмэнд дасалтай хүмүүст уламжлалт анагаах ухааны оношлогоо, эмчилгээг хийж эмчлэх, хөнгөвчлөх эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх, түүний үр дүнг оролцогч байгууллага хамтран судалж гаргах.
1. Сургалт, суртчилгаа, оролцогч талууд

Эрүүл мэндийн яамнаас “Сүрьеэ өвчний эмчилгээний гаж нөлөөг уламжлалт анагаах ухааны эм, тангаар засах сургалтын удирдамж” гарсантай холбогдуулан “Манба Дацан” нэгдсэн эмнэлэг, “Оточ Манрамба” их сургуулийн эрдэмтэн эмч, багш нар, ХӨСҮТ-ийн СТСА-ны эмийн асуудал хариуцсан мэргэжилтэн, 2021 оны 12 дугаар сарын 10, 13, 14-ны өдрүүдэд танхимын болон цахим сургалтуудыг хийж гүйцэтгэв.

ЭМЯ, Глобаль сангийн ХЗН, ХӨСҮТ, аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер, Нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн эмч нар, Уламжлалт анагаах ухааны онолоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүд.

Тус сургалтанд Нийслэлийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын УАУ-ны эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Нийслэлийн төрийн эрүүл мэндийн байгууллагын УАУ-ны эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын УАУ-ны эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдээс нийт 210 хүн хамрагдав.

Уламжлалт анагаах ухааны эмч мэргэжилтэнгүүд сүрьеэ өвчнийг эмчлэхэд хууль эрх зүйн таатай нөхцөлүүд байна.

- Монгол улсын эрүүл мэндийн хууль,
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль,
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль,
- Монгол улсын эрүүл мэндийн сайдын тушаалууд
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага Номхон далайн баруун эргийн Уламжлалт анагаах ухааны бүсийн стратеги

Сүрьеэ өвчний талаарх бодлого, хууль, стрататеги

Монгол улсын эрүүл мэндийн тухай хууль	
4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчим	4.2.1. Хүмүүнлэг, энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэг, ололт, нотолгоо, орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэт аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх;
16 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж,үйлчилгээ үзүүлэх байгууллагын чиг үүрэг	16.19. Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг монголын уламжлалт анагаах ухааны үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Монгол улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	1.1. Энэ хуулийн зорилт нь хүний болон мал эмнэлгийн зориулалттай эм, түүний дотор уламжлалт эм, биобэлдмэл, оношлуур /цаашид “эм” гэх/, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	3.1.3. “Уламжлалт эм” гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх зорилгоор тодорхой тун, хэмжээгээр хэрэглэдэг, уламжлалт анагаах ухааны жорын дагуу ургамал, амьтан, эрдсийн гаралтай бодис болон үнэт эрдэнэс оруулан уламжлалт болон үйлдвэрийн аргаар бэлдсэн байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг;

Монгол улсын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль	
3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт	3.1.1. "Эмнэлгийн тусламж, үйлчилгээ" гэж өвчин эмгэг, гэмтэл бэртэл, хүний биеийн үйл ажиллагааны алдагдлыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах цогц үйл ажиллагааг;
5 дугаар зүйл. Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт	5.1.Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, хянах, эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах үйл ажиллагааг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ хамаарна.

Монгол улсын эрүүл мэндийн сайдын тушаал 2021.01.27


Дугаар: А/30

Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, заавар батлагдсан сайдын тушаалыг дагаж мөрдөн, судлах асуудлыг анхаарч авч үзэх.

ДЭМБ. Номхон далайн баруун эргийн Уламжлалт анагаах ухааны бүсийн стратеги



ДЭМБ. Номхон далайн баруун эргийн Уламжлалт анагаах ухааны бүсийн стратеги



Уламжлалт анагаах ухаанд сүрьеэ өвчний талаар авч судлагдсан мэдлэг ухаан

Эрүүл орших, өвчнийг оношлох, эмчлэх хий, шар, бадганы гурван төлөв арвидах, барагдах, хямрахгүйгээр өөр өөрийн хэм хэмжээндээ эрүүл байх, өвчин эмгэг, халдвар авсан нөхцөлд өвчний шалтгаан, нөхцөл, хувирах ёс, ангилал, шинж тэмдэг, оношлох, эмчлэх хувь хүн болоод нийгэм даяараа эрүүл оршихын гүн утга учирыг системчлэн авч үзсэн уламжлалт анагаах ухааны томоохон цогц систем байна.

Одоогоос 2973 жилийн тэртээ сүрьеэ өвчний талаар уламжлалт анагаах ухаанд авч үзэж байжээ. Төвдийн алдарт эмч Ютог-Ёндонгомбо бээр анагаах ухааны цог төгөлдөр дөрвөн үндсийг МТ 763 онд эмхэтгэж бичсэн. Улмаар Төвдийн Манлүн-д анагаах ухааны харваас үзэсгэлэнтэй хэмээх сургууль байгуулж түүнд Монголчууд суралцаж байсан хэмээн түүхэнд байдаг. Сүрьеэ өвчний талаар Монгол Төвдийн алдартай анагаах ухаантнуудын бичиж туурвисан олон мянган ном, сурах бичиг, мэдлэг ухаан байна. Үүнээс харахад Монголчууд сүрьеэ өвчний оношлогоо, эмчилгээний талаар өнө эртний түүхэн уламжлалтай байжээ. Одоо ч бидэнд сүрьеэ өвчнийг анагаах оношлогоо эмчилгээний онол, шүн, мэдлэг чадвар өвлөгдөн уламжлагдан ирсэн байна.

Сүрьеэ нэрний утга, хамт төрсөн



Сүрьеэ хэмээх нь санскрит нэр бөгөөд Төвд хэлэнд гурван янзаар бичигджээ. Утга нь: Нар, нарны цацраг, гэрэл цацрах, гэрэл гялбаа хэмээх тархмал хэмээсэн утгуудыг агуулдаг байна.


- Рашааны шим гишүүн найм нууц увидасын үндэс хэмээх сурах бичгийн Увдасийн үндэсийн 8-р үесийн хамт төрсөн найман шарх өвчний ангилал төрөл зүйлийн дотор сүрьеэ өвчнийг багтаан авч үзсэн байдаг.
- Хамт төрсөн хэмээхийг авч үзвэл энэ нь бодьтой нэгэн эх үүсвэр өнө эртнээс хувь бодгалтай хамт үүссэн бөгөөд төрөлх мөн чанар нь далд оршиж байгааг хэлнэ. Тэргүүлэгч үгүй цагаас хамт сацуу бий болсоныг хэлнэ.
- Хамт төрсөн шарх хэмээх нь өвчний үүсгэгч өөрийн бие эрхтэнтэй хамт буй болж бүтэцийн өөрчлөлт нь шарх болно хэмээн авч үзжээ.
- Сүрьеэ өвчнийг эмчлэхэд юуны түрүүнд ард иргэдийг эрүүл орших ухаанд суралцуулах нь машид чухал бөгөөд энэ талаар Язгуурын үндэс-д бие сэтгэлийн эрүүл оршихийг чухалчилан авч үзсэн байдаг. Үүнээс харахад зөвхөн сүрьеэ өвчин төдийгүй Монголчууд эрүүл амьдрах ёс зүй, мэдлэг, боловсрол хэдий чинээ өндөр байх тусам эрүүл оршиж, амар амгалантай амьдрах нь бодьтой юм.

Өвчингүй эрүүл орших

- Хий, шар, бадган, долоон тамир, гурван хир өөр хоорондоо шүтэлцэн, хэвийн хэмжээндээ эрүүл байх нь өвчингүй оршихын үндэс хэмээн авч үздэг.
- Хүний бие дахь бодисын солилцоо, дархлааны систем, хий, шар, бадган, тунгалаг, цус, мах, өөх, яс, чөмөг, дусал, өтгөн, шингэн, хөлс хэвийн хэмжээнд эрүүл байх бие, сэтгэлийн зовлонгүй байх цаг, ад, идээ, унд, явдал мөр нөхцөлөөр илүүдэж, дутуудаж, буруудаагүй тохиолдолд өвчингүй орших үндэс болно. Эдгээр бүгдийг хэвийн байлгаж чадсан тохиолдолд өвчингүй урт наслаж удаан жаргах нь дамжиггүй юм.
- Бие, хэл, сэтгэлээр үйлддэг арван хар нүгэл тэргүүтэн хүмүүний ёс зүйгүй, мэдлэг боловсролгүй, мунхаг, нисваанисын муу нүгэлтэй үйлийг үйлдэхгүй боомтлон хорих. Бие, хэл, сэтгэлийн ариун ухамсарт мэдлэг, асарч энэрэн нигүүлсэх, зөв


ёс зүй ном буянтай сайн үйлийг сэргээн хөгжүүлэх нь эрүүл оршихын үндэс болно.

- Эрдэнэт хүмүүний төрлийг олсон хэн боловч амар амгаланг хүсдэг мөртлөө тэрхүү амар амгаланг бүрдүүлэхэд шаардлагатай шалтгаан, нөхцөлийг хувь хүн өөрөө буй болгож эрүүл мэндээ хохироодог боловч өөрийнхөө гэм бурууг мэдэхгүй бусдаас гэм хайдаг буруу үзэл бодол энэ орчин цаг үед ихээхэн дэлгэрч байна. Монголчууд сүүлийн үед өөрийгөө мэнэмхийлэх, атаа хорсол, шунал, хүсэл, омог дээрэнгүй, муу нисванисын сэтгэлүүдийг хяналтгүйгээр үйлдэж байгаа нь хувь хүний эрүүл мэндэд маш хор хохиролтой гэдгийг ойлгохгүй байгаа нь эрүүл мэнд, соён гэгээрүүлэх мэдлэг боловсрол ихээхэн хэрэгцээтэйг харуулж байна.
- Нийгмийн эрүүл мэндийг ярихад юуны түрүүнд хүний боловсрол, мэдлэг, сэтгэлийн ёс зүй, дадал хэвшлийг авч үзэх нь юу юунаас чухал юм. Эрүүл орших, эрүүл мэндийн ёс зүйг ухамсар, сэтгэлтэй нь холбож авч үзэхгүй тохиолдолд хувь хүн болоод нийгэм эрүүл оршиход муу, сөрөг үр дагавар ихээхэн буй болно.
- Тиймээс эрүүл оршиж өвчин зовлонгүй, урт наслаж, эд баялаг, эрдэм ном, боловсрол, эрч хүч, эв түнжин, амар амгаланг буй болгоход нүгэл, буян хэмээх хоёр зүйл маш чухал гэдгийг цаашид мэдэж судлах хэрэгцээ шаардлага байна. Энэ талаар буддын сургаал, ном судар болон уламжлалт анагаах ухаанд эрүүл өвчингүй орших талын мэдлэг боловсролыг ихээхэн авч үзсэн байдаг.
- Хүний бие сэтгэл эрүүл байх, өвчин эмгэг үүсэхэд нөлөөлдөг мунхаг, нисваанисийн сэтгэлүүд хий, шар, бадган, долоон тамир, гурван хир, хий, шар, бадганы бэлгэ чанар, үйл ажиллагааны үйлдэл хамаарал, таван махбодын онол, өвчнийг үүсгэх нөхцөлийг авч судлах нь оношлогоо, эмчилгээг чанартай үр дүнтэй хийхэд хамааралтай бөгөөд сүрьеэ өвчний үед ч гэсэн эдгээр онол, дадлагын асуудлуудыг анхааран авч үзэх хэрэгтэй юм.



Биеийн тамир	Үйлдэл	Гүйцэт хэмжээ
Биеийн тамир: идээ ундааны тунгалаг болон цус тэргүүтэнээр биеийг амьдруулж үйлддэг махбодын шүтээн тунгалаг.		
Тунгалаг	Ялзлах, шингээх, ялгах гурван галын илчээр тунгалаг, цөв ялгаруулдаг идээ ундааны тунгалаг. Хорлогдохууныг арвидуулж үйлдэнэ.	1 чорва
Цус	Идээ ундааны тунгалагийн тунгалаг бөгөөд биеийг чийгшүүлэх бөгөөд амийг амьдруулж үйлддэг биеийн тамир.	7 нимба (дунджаар 4-5 литр)
Мах	Цусны тунгалаг бөгөөд биеийг гадна, дотор, завсарт бүрхэж үйлддэг бөгөөд мөн чанар нь нялцгай, улаан өнгөтэй биеийн тамир.	Эр- 500 атга Эм-520 атга
Өөх	Махны тунгалаг бөгөөд биеийг тослослогжуулна, өнгө нь шар, цайвар биеийн тамир.	2 нимба
Яс	Өөхний тунгалаг бөгөөд мөн чанар нь чийрэг, биеийг батжуулдаг тулгуур. Өнгө нь цагаан биеийн тамир.	360
Чөмөг	Ясны тунгалаг бөгөөд биеийг шимжүүлнэ. Цайвар шаргал өнгөтэй биеийн тамир.	-
Дусал	Чөмөгний тунгалаг бөгөөд умайд орших хөрөнгө болох биеийн тамир.	1 чорва

Хир	Үйлдэл	Гүйцэт хэмжээ
Хир: өтгөн, шингэн, хөлс тэргүүтэн бие махбодын цөв.		
Өтгөн	Идээний эцсийн цөв.	7 нимба
Шингэн	Ундааны эцсийн цөв.	4 нимба
Хөлс	Биеийн илчлэг махбодын цөв бөгөөд шар үсний нүхээр гадагшилах шингэн. Арьсийг зөөлрүүлэх бөгөөд шар үсийг батлаг болгоно.	-



Өвчний холын шалтгаан

Холын ерөнхий шалтгааныг хураангуйлан авч үзвэл өвчин бүгдийн шалтгаан ганцхан бөгөөд би үгүй утгыг эс оносон мунхаг хэмээн авч үзсэн.

Холын ялгавартай шалтгаан нь мунхагаас хэмээх холын шалтгаанаас үүсэлтэй хүсэл тачаал, уур хилэн, тэнэг мунхаг гурван хорын асуудлыг авч үздэг байна.

Дээрх хоёрын ялгааг эс онож мунхуурсанаас үүссэн тэнэг мунхаг. Эдгээр гурав нь эцэстээ амь, биеийг хөнөөж үйлддэг хор хэмээсэн. Мөн эдгээр гуравыг ертөнцийн гурван хор хэмээн нэрлэдэг.

Нисваанис

Нисваанис хэмээх ойлголт нь бие, сэтгэл зовох хэцүү үйл буюу ядрах, зүдрэхийг хэлнэ. Нисваанис нь нүглээр үүсэж хөдөлдөг, өөрийнхөө бие, сэтгэлийг ариусгаж амирлуулж чадаагүй сэтгэл юм.

Нисваанисын түйтгэр нь гэтлэхийг /хүлээснээсээ тайлагдах/ орчлонд хүлэгдсэн үйл, нисваанис хоёрыг огоотод боомтлох олоход гэг тотгор болдог харам тэргүүтэй тийн атгаглах, оюун санаа, сэтгэлүүд болно. Би-д барих нарийн бүдүүн хөрөнгө сэлт, түүний эрхээр гарах гурван хорын хөрөнгө сэлт.

Мэдэгдэхүүний түйтгэр нь тийн бүгдийг болгоогчийг олоход саад, тотгор их, дунд, бага гурван тийн атгаглах сэтгэл.

Хамт төрсөн нисваанис- Бүтээлийн хязгаар оюун ухаанаар хувирахгүйгээр амьтны үндсэнд нь мөн чанараараа байгаа нисваанис юм.

Хамт төрсөн мунхаг- Амьтан бүхний уг үндэст байгаа мэнэмхийлэн барих мунхагийг тэнэг мунхаг хэмээжээ.

Өвчний холын шалтгаан

Ялгавартай авч үзвэл 3 хор, 5 хор, 20 нисваанис түүнээс салбарласан 84000 мунхаг нисваанисийн сэтгэл багтдаг. Эдгээрийг задлан авч үзвэл Хий-21000, шар-21000, бадган-21000, дээрх гурав холилдож хурсан-21000 мунхаг нисваанисын сэтгэл байна.

- » Гурван хорын мунхаг нисваанисын сэтгэлд - хүсэл тачаал, уур хилэн, тэнэг мунхаг багтана.
- » Таван хор мунхаг нисваанисын сэтгэл - хүсэл тачаал, уур хилэн, тэнэг мунхаг, омог дээрэнгүй, атаа хорсолын сэтгэлүүд багтана.
- » Хорин мунхаг нисваанисын сэтгэл - Уурлах, өс хонзон, нуух, ундууцах, атаа, харам, хуурах, дээрэнгүй, омог, асар хөнөөх, ичгүүргүй, сонжуургүй, будангуйрах, догшин, эс сүсэглэгч, залхуу, сэрэмжгүй, мартамхай, сэтгэл алгасрах, болгоомжгүй сэтгэлүүд багтана.

Өвчин бүгдийн ойрын шалтгаан

Гурван хороос үр хий, шар, бадган гэм үүсдэг. Дүр эс урвасан хий, шар, бадган нь өвчний ойрын шалтгаан болно. Дүр урваж тэгш бус болсоноор өвчний мөн чанартай болж бие болон амийг хорлох бөгөөд энэлэх болно.

Өвчингүй оршихын үндэс

- » Мунхаг үгүй болвоос нисваанис үл гарна
- » Нисваанис үгүй болбоос хүсэл тачаал үл гарна
- » Хүсэл тачаал үгүй болбоос хий өвчин үл гарна
- » Мунхаг үгүй болвоос нисваанис үл гарна
- » Нисваанис үгүй болбоос уур хилэн үл гарна
- » Уур хилэн үгүй болбоос халуун, шар өвчин үл гарна
- » Мунхаг үгүй болвоос нисваанис үл гарна
- » Нисваанис үгүй болбоос тэнэг мунхаг үл гарна

- » Тэнэг мунхаг үгүй болбоос хүйтэн, бадганы өвчин үл гарна

Хий, шар бадганы 20 бэлгэ чанар

Хийн бэлгэ чанар

- » Ширүүн –биеийн хүрэлцэхүй ширүүн зөөлөн бус, сэтгэлийн махбод ширүүн бөгөөд сэтгэл тогтворгүй.
- » Хөнгөн –биеийн хөнгөн нь явж, суух нь тогтворгүй, сэтгэлийн хөнгөн нь сэтгэл долгисно, хий түүнийг ерөндөгөөр засах хялбар тул хөнгөн.
- » Хүйтэн –биеийн хүйтэн нь даарч жихүйцэх, сэтгэлийн хүйтэн нь гаслан болно.
- » Нарийн –хийний орох нь нарийн тул бие, сэтгэл бүгдэд орж нөлөөлнө.
- » Чийрэг –зөөлний хувиас буцсан хатуувтар.
- » Хөлбөрөнхий –хий махбод голлоод, орон нэгд тогтвортой бус хөлбөрөн хөдлөх.

Шарын бэлгэ чанар

- » Тослог –тослогоор илчийг бадрааж үйлдэнэ.
- » Хурц –орно, түгэх нь хурдан
- » Халуун –илч лугаа төгөлдөр
- » Хөнгөн –дээш бадруулан түгээх
- » Үнэр муухай –халуунаар түлсэнээс муухай үнэр гаргана
- » Суулгах –шар шингэнээр туулгах
- » Нойтон –чийгтэй

Бадганы бэлгэ чанар

- » Тослог –өөх, хориуны махбод
- » Сэрүүн –хүйтний хувь
- » Хүнд –усны мөн чанараар доош дарагдах хүч төгөлдөр
- » Мохдог –ороод түгэж хөдлөх

- » Зөөлөн –хүрэлцэхүй ширүүн бус
- » Батлаг –урвуулах нь бага
- » Наалдамхай –махбодыг наалдуулах хүч

Үндсэн таван хий, шар бадганы ангилал, орон, үйлдэлийг тодруулан үзвэл:

Хий

№	Ангилал	Орших орон	Үйлдэл
1.	Амь баригч хий	Толгой оройн хэсэгт оршино.	Хоолой, өвчүү тэргүүтнийг хамрана. Идээ, ундыг залгих. Амьсгал авах, шүлс гаргах, найтаах, хэхрэх тэргүүтнийг үйл ажиллагааг зонхилон зохицуулах. Оюун ухаан, эрхтэн ситемийг тодруулна хамаарч сэтгэлийн үйл ажиллагааг бүхэлд нь хамаарна.
2.	Дээш гүйгч хий	Өвчүүнд оршино.	Хамар, хэл, хоолойг хамрана. Дуу авиаг гаргана. Бие, сэтгэлийн хүчийг үүсгэнэ, арьсны өнгийг тодруулж үйлдэнэ, хичээл шамдал, дурдлыг тодруулна.
3.	Түгээгч хий	Зүрхэнд оршино.	Бие сэтгэлийн эрхтэн систем бүгдийг хамрана.Өргөх, тавих, явах, жийх, хумих, эрхтэний үүд ийг нээх, хаах, шар үсний үүдийг нээх тэргүүтэн олон үйлийг үйлдэнэ.
4.	Гал тэгшитгэгч хий	Ходоодонд оршино.	Гэдэс дотор бүгдийг хамрана. Идээ ундааг шингээж, тунгалаг, цөвийг ялгаруулах үйлдлүүдийг хамрана.
5.	Урвуу арилгагч хий	Хошногонд оршино.	Олгой, давсаг, нууцын эрхтэн, умай, гуя тэргүүтнийг хамрана. Дусал, цус, өтгөн, шингэн гаргахыг , хааж боож үйлдэлүүдийг хамрана.


Шар

№	Ангилал	Орших орон	Үйлдэл
1.	Шингээгч шар	Ходоод, олгой шингэх, эс шингэхийн завсарт оршино.	Идээ ундааг шингээж, тунгалаг, цөвийг ялгаруулан бодисийн солилцоог үйлдэж биеийн илчийг үүсгэнэ, бусад дөрвөн шар-д нөхөр болон хүчийг үүсгэнэ.
2.	Өнгө хувиргагч шар	Элгэнд оршино.	Тунгалаг цус, мах, өөх, яс тэргүүтний өнгийг хоцроолгүй хувиргах үйлдлийг хамрана.
3.	Бүтээгч шар	Зүрхэнд оршино.	Сэтгэлийн чиг хандлагыг тодруулж, омог, оюун санаа, хүсэл зорилгийг бүхэлд нь хамрана.
4.	Үзүүлэгч шар	Нүдэнд оршино.	Харааны мэдрэмж дүрсийг хамрана.
5.	Өнгө тодруулагч шар	Арьсанд оршино.	Арьсны өнгийг тодруулна.

Бадган


№	Ангилал	Орших орон	Үйлдэл
1.	Шүтүүлэгч бадган	Өвчүүнд оршино.	Бадганы бусад дөрвөн төлөвт эерэг сөрөгөөр нөлөөлнө.
2.	Ялзлагч бадган	Эс шингэсэнд оршино.	Идээ ундыг ялзлах тэргүүтэн шингэлтийн үйл ажиллагаа
3.	Амсуулагч бадган	Хэлэнд оршино.	Амтлахуйн бүхий л мэдрэхүйг хамаарна.
4.	Цэнгүүлэгч бадган	Толгойд оршино.	Нүд, чих, хамар, амт, хүрэлцэхүй эрхтэн хийгээд оюун санааг цэнгүүлэн, сэтгэл мэдрэлийн асуудлыг хамаарна.
5.	Барилдуулагч бадган	Бүх үесд оршино.	Үесийг барилдуулж, атийх, тэнийх хөдөлгөөний механизмийг бүхэлд нь хамрана.

5 махбод			5 махбод хураагдах ёс	5 эрхтэн хураагдах ёс
Шороо	ᠰᠣᠷᠣᠭ ᠤᠭᠣᠢ -Шороо үгүй бол үл бүтнэ	Мах, яс, хамар, үнэр үүснэ.	Шороон махбодын чадал усанд шингэснээр биеийн дүрс эвдэрнэ, хөдөлгөөн хязгарлагдана, харааны эрхтэн мэдрэл системүүд бүгд доройтож эвдэрнэ,	Нүдний эрхтэн дүрсийг үзэхгүй, дуунд шингэнэ.
Ус	ᠤᠰ ᠤᠭᠣᠢ -Ус үгүй бол хурж чадахгүй	Цус, хэл, амт, чийг үүснэ.	Усан махбодын чадал галд шингэснээр усан махбод хураад бүх нүх, сүв хатна.	Чихний эрхтэн доройтсоноор дуу сонсохгүй, үнэрт шингэнэ.
Гал	ᠭᠠᠯ ᠤᠭᠣᠢ -Гал үгүй бол боловсрохгүй	Илч, өнгө тодруулагч, нүдний дүрс үүснэ.	Гал махбодын үйл ажиллагааны чадал нь хийд шингээд биеийн гадна илч зэрэгчлэнгээр хураад	Хамрын эрхтэн доройтсоноор үнэрлэхгүй, амтанд шингэнэ.
Хий	ᠬᠢᠢ ᠤᠭᠣᠢ -Хий үгүй бол арвидаж чадахгүй	Амьсгал, арьсны хүрэлцэхүй үүснэ.	Хий махбодын чадал огторгуйд шингэснээр гадна амьсгал тасарна.	Хэлний эрхтэн доройтсоноор амт мэдрэхгүй, хүрэлцэхүйд шингэнэ.
Огторгуй	ᠣᠭᠲᠣᠷᠭᠣᠢ ᠤᠭᠣᠢ -Огторгуй үгүй бол арвидахын завсар үл ялгармуй.	Нүх сүв, чих, дуу үүсэх болно.	Амин хий болон намштай холбогдоно. Есөн сүвээр юүлэгдэнэ.	Биеийн эрхтэн доройтсоноор хүрэлцэхүй мэдрэхгүй.



Хүний бие, сэтгэлийн эрүүл тэнцвэртэй оршиж байхад бидэнтэй хамт буй болсон өвчин үүсэхэд нөхцөл болон нөлөөлдөг цаг улирал, гадна дотны ад харшлах зүйл, идээ ундаа, явдал мөр, /бие, хэл, сэтгэлийн/ нөхцөл хамаарлыг анхааран авч үзэх нь чухал юм. Эдгээр дөрвөн нөхцөлын илүүдэх, дутуудах, буруудах үйл явцыг сайтар нягтлан авч үзэх.

Өвчин үүсгэх нөхцөл



Бие, сэтгэлийн эрүүл амар, амгаланг олоход хүнд заяагдсан давуу талууд

№	Сайн	Буян
1.	Хамт төрсөн бэлгэ билгүүн	
2.	Хамт төрсөн хоосон чанар	
3.	Нинж асрал	
4.	Арван цагаан буян	
5.	Бодь сэтгэл	
6.	Бага хөлгөн –дайсанаа дарсаны үрийг олно. Нянтай, аранжил	Нисваанисын түйтгэрийг боомтолж, би үгүйн үзлийг онож мэддэг.
7.	Их хөлгөн –бодьсадва арван газар бүгдийг болгоогч бурхан	Нисваанисын түйтгэр болон мэдэгдэхүүний түйтгэр арван газрыг онож хүрээд, རྩོ་ཉིད་སྒྲ། ཡེ་ཤེས་ཚུལ་སྒྲ། རྩོད་སྒྲ། ལྷུ་ལ་སྒྲ། ཀླུ་ལ་སྒྲ། ལྷེ་མཚན་གྱི་སྒྲུལ་སྒྲ། གྲོ་བ་ཚོ་དེ་སྒྲུལ་སྒྲ། དེ་ལྷ་ཚོགས་པ་འཁྲུག་སྒྲུལ་སྒྲུབ།


2. СҮРЬЕЭ ӨВЧНИЙ ОНОШЛОГОО, ЭМЧИЛГЭЭ

Хүний өдөр тутамд хэрэглэдэг идээ ундааны зүйл нь амь баригч хийний үйлдлээр ходоодонд хүрч ялзлагч бадган, шингээгч шар, гал тэгшитгэгч хийн үйлдлээр тунгалаг цөв ялгарах үйл явц явагдана.

Долоон тамир, гурван хирийн тус бүрийн галын илч, тунгалаг, цөвийг элэг тэргүүтэн эрхтэн системээр дамжуулан бодисын солилцооны цогц үйл ажиллагааг бүхэлд нь хамран явуулна.

Хий шар бадганы гурван хүч нь аривдаж, хорогдож, буруудсанаар тунгалаг, цөв өөр өөрийн гүйх мөр, орон эрхтэнүүдийн үйл ажиллагааг хямруулснаар муу цус, шар усаас хамааралтай сүрьеэ өвчнүүдийг үүсгэх шалтгаан, нөхцөл нь бүрддэг.

Оношилгоо эмчилгээнд харгалзах 10 хүчин зүйл



Оношилгооны 10 хүчин зүйл		Хий бэлгэ чанартай зохицсон
1	Шалтгаан, нөхцөл	Шалтгаан нь мунхаг түүнээс үүсэх хүсэл тачаал, нөхцөл нь хийг үүсгэж хөдөлгөх цаг, ад, идээ, явдал мөр
2	Өвчтөний орших орон	Жавартай хүйтэн, сэрүүн салхитай орон байр, газар нутаг нь хийг хөдөлгөх орон
3	Цаг улирал	Зуны Чүдод, Дошин саруудад хий хөдлөх сар
4	Өвөрчлөл	Хийн өвөрчлөлтэй
5	Нас	70-аас дээш нас
6	Өвчин орших орон	Дүр урвасан хийн орон, биеийн доод хэсэгт
7	Хоногийн хэмнэл	Үдэш, үүрээр хий хөдөлнө
8	Идээний шингэлт	Идээ шингэсний хойно хий хөдөлнө
9	Дадуулга	Шимгүй идээ
10	Шээс	Хий арвидсан шинж илрэх

Оношилгооны 10 хүчин зүйл		Шарын бэлгэ чанартай зохицсон
1	Шалтгаан, нөхцөл	Шалтгаан нь мунхаг түүнээс үүсэх уур хилэн, нөхцөл нь шарыг үүсгэж хөдөлгөх цаг, ад, идээ, явдал мөр
2	Өвчтөний орших орон	Хуурай, халуун, бүгчим газар орон
3	Цаг улирал	Намрын Түмдод, Тагар сар, Тэжээлийн улирал Нон сар
4	Өвөрчлөл	Шарын өвөрчлөлтэй
5	Нас	16-70 нас
6	Өвчин орших орон	Элэг, цөс, биеийн дунд хэсэгт
7	Хоногийн хэмнэл	Өдөр дунд, шөнө дунд
8	Идээний шингэлт	Идээ шингэх цагт
9	Дадуулга	Илчлэг халуун чанартай, шимтэй идээ унд, явдал мөр
10	Шээс	Халуун өвчний шинж илрэх

Оношилгооны 10 хүчин зүйл		Бадганы бэлгэ чанартай зохицсон
1	Шалтгаан, нөхцөл	Шалтгаан нь мунхаг түүнээс үүсэх тэнэг мунхаг, нөхцөл нь бадганыг үүсгэж хөдөлгөх цаг, ад, идээ, явдал мөр
2	Өвчтөний орших орон	Чийгтэй тослог орон байр, газар нутаг нь бадганыг хөдөлгөх орон болно:
3	Цаг улирал	Өвлийн Миндүг, Гожал сар нь бадган хөдлөх сар
4	Өвөрчлөл	Бадганы өвөрчлөлтэй
5	Нас	0-16 нас
6	Өвчин орших орон	Дүр урвасан бадганы орон, биеийн дээд хэсэгт
7	Хоногийн хэмнэл	Бүрий, өглөө бадган хөдөлнө
8	Идээний шингэлт	Идээ идсэн даруйд бадган хөдөлнө
9	Дадуулга	Бадган арвидсан шинж илрэх
10	Шээс	

Сүрьеэ өвчний ангилал

Сүрьеэ өвчнийг уушиг, элэг, бөөр, ходоод, олгой хэмээн нэгтгэн авч үзсэн боловч энэ нь тунгалаг, цөв, хий, шар, бадган, хурмал өвчин, хорхой / нян, вирус, бактери/ халууны халдварт өвчин, эс шингэсэн, хорын өвчин, шар усны өвчин, булчирхай, цул сав эрхтэний махбодийн уялдаа холбоо, өвчлөл зэрэг хүрээ хэмжээнд авч судлагддаг байна.

Сүрьеэ өвчнийг уушиг, элэг, бөөр, ходоод, олгой хэмээн авч үзсэн нь цул савын онолоор:

- Уушиг төмөр махбодтой, амьсгал хийн шүтээн эрхтэн. Олгой нь хурсан идээний цөвийг хураадаг сав эрхтэн бөгөөд төмөр махбодтой тул уушгитай махбодын эрхээр барилдана.
- Элэг модон махбодын шүтээн эрхтэн. Цөс нь гал адил цөвийн сав эрхтэн бөгөөд модон махбодтой тул махбодын эрхээр элэгтэй барилддаг.
- Бөөр нь усан махбодийн тунгалгийн шүтээн эрхтэн. Давсаг нь шээсийг хураадаг сав эрхтэн бөгөөд усан махбодтой тул бөөртэй махбодын эрхээр барилддаг.
- Дэлүү нь шороон махбодын тунгалгийн шүтээн эрхтэн. Ходоод нь цөв сальсыг хураадаг сав эрхтэн бөгөөд шороон махбодтой тул дэлүүтэй махбодын эрхээр барилддаг.

№	Ангилал	Шинж
1.	Уушиг	Суганы доор хавдана, цээжээр хатгаж олон ханиалгана
2.	Элэг	Элэгний дээр хавдана, цээж дүүрсэн мэт санагдаад, хэвтэж чадахгүй
3.	Бөөр	Бөөрний дээр хавдаж, шээс чавдагшина
4.	Ходоод	Хөөж, хоржигноно, ходоодны дээр хавдана
5.	Олгой	Хөөж, хоржигноно, олгой хавдана

Сүрьеэ өвчний үеийн судас оношлогоо

Судас, шээс оношилж мэдэхгүй эмч тэр нь үйл ажиллагаа, мэдээллийг буруу ойлгож түгээх адил халуун, хүйтэн өвчнийг ялган өгүүлж чадахгүй хэмээсэн.

Зөв бодит мэдээ мэдээллийг хүргэгч нь мэдээллийг буруу хүргэж байгаа үйлдэлтэй адил судас шээсний онол шүнг мэдэхгүйгээр

судас шээсээр дамжиж буй өвчний нарийн ялгаатай мэдээллүүдийг ч мэдэхгүйгээр буруу оношлох, эмчлэх, эмчийн алдаа эндэгдлийг анхааруулсан сануулга юм.

Монголын уламжлалт анагаах ухаанд судас, хэл, шээсийг оношлох, таван эрхтнийг шинжлэх, биеийг шинжлэх, нүүр царайг шинжлэх, таван эрхтэний ургах орныг шинжлэх, таван хирийг шинжлэх зэргээс судас, хэл, шээс оношлогоог маш өндөр хэмжээнд авч үзвэл өвчин бүгдийг эндүүрэлгүй бүрэн гүйцэт оношлож, эмчилж чадна хэмээн онолд гардаг тул чухалчилан авч үзэх хэрэгтэй юм.

Сүрьеэ өвчний судас оношлогоо, товчлол

Хүний бие махбод хий, шар, бадганы бэлгэ чанар урваагүй, өвчингүй, эрүүл оршиж байх үед шинжлэх судасны лугшилтын ялгал нь тухайн бие махбодын шүтээний мөн чанар, эхийн хэвлийд бүрэлдсэн ёсны эрхээр гурван үндсэн судсанд хурдаг. Үүнд:

1. Эр судас нь хийн бэлгэ чанартай зохицон бүдүүн баргил лугшина.
2. Эм судас нь шарын бэлгэ чанартай зохицон нарийн, түргэн лугшина.
3. Бодь сэтгэлтний буюу манин судас нь бадганы бэлгэ чанартай зохицон гүйдэл нь урт, зөөлөн, эелдэг лугшина.

Ялгавартай судасны лугшилт

Дан хий өвчний судас нь тулмыг хийгээр үлээж тэлсэн мэт хөндий бөгөөд бүдүүн, дээрээ өндөр лугшина. Дарахад үл тэсвэрлэх бөгөөд хоосон, лугшилтын тоо магадтай бус, үе үе лугшихгүй зогсоно.

Дан шар өвчний судас нь дээрээ нарийн, доороо хэнгэрэг дэлдэж байгаа мэт эрчимтэй лугшина. Дарсан ч лугшилт нь хоосорч алга болохгүй.

Дан бадган буюу цайвар бадган өвчний судасны лугшилт нь тодрохгүй, ёроолдоо живэнхүй, дорой, гүйхдээ бэрх.

Хий, халуун хавсарсан өвчний судасны лугшилт нь хийн талаас хоосон, халууны талаас түргэн, гүйж лугшина.

Бадган, шар хавсарсан өвчний судасны лугшилт нь бадганы эрхээр амандаа живэнхүй, шарын эрхээр ёроолдоо эрчимтэй лугшина.

Бадган, хий хавсарсан өвчний судасны лугшилт нь хийн эрхээр хоосон, бадганы эрхээр удаан лугших бөгөөд судасны гүйдэл нь бодитой бус, дорой лугшина.

Бадган бор өвчний судасны лугшилт нь хийн талаас бүдүүн, цусны талаас дүүрэн, элгэнд бадган оршсоны эрхээр гангийн дор судас балархай буюу судас нь дүүрэн биш хавтгай лугшина.

Нэр	Халуун өвчний лугшилт	Хүйтэн өвчний лугшилт
Судасны мөн чанар	Дэлгэрэнгүй	Живэнхүй
	Эрчимтэй	Сул
	Хатуу	Хоосон
Судасны лугших ёс	Хүчтэй	Балархай
	Хуйларсан	Дорой
	Түргэн	Удаан

Судсаар үхлийн шинжийг таних

1. Гурван гэм дэн, хавсарсан, хурсан, өвчнөөр үхэх шинж судсанд илрэх.
2. Цул эрхтний судас эс бүрдэх нь үхлийн шинж байаг боловч магадтай үхэх, эс үхэхийг шинжлэхдээ дотор цул, сав эрхтэн, гадна мэдрэхүйн эрхтнүүдийн барилдлагыг уялдуулан шинжилдэг.
3. Судасны лугшилт дарааллан үргэлжлэх хугацаанд нэжгээд төдий үл лушгин зогсохыг зогсолт гэдэг.

Адад хорлогдсон үед судасны лугших ёс нь баруун, зүүн, дээр, доор, цул сав, халуун, хүйтэн тэргүүтэн тэгш бус лугших бөгөөд байн байн урваж буцах нь олон, тоо нь магадтай бус зогсох, таталдах, зэрэгцэх тэргүүтэн элдэв гэмийн лугшилт илэрдэг.

Сүлд судас нь лугших судас бөгөөд зүрхтэй барилдсан байдаг тул зүрхний цохилттой зохилдон лугшдаг. Сүлд судас нь тохойны хонхорын асогийн дороос салж доод өнцгийн бүлх, шөрмөсний завсраар дамжиж ядам хуруу лу чиглэсэн лугших судас юм. Сүлд нь амь настай хамт байдаг ба тэр нь сүлд судасны дотор ядам хуруугаар дамжиж гадагш тэнэж байдаг.

- Цусны өвчний лугшилт нь мөн чанар нь дээрээ овойж, утас эрчилсэн мэт хуйларч лугших боловч жирэмсэн эмэгтэйн судаснаас бага зэрэг удаан лугшина.
- Шар усны өвчний судасны лугшилт нь чичирч гүйхдээ бэрх лугшина.

- Хорхойн өвчний судасны лугшилт нь ороох мэт лугших бөгөөд лугшилтын үргэлжлэл нь шахагдаж хавтгайрч лугшина.
- Халдварт халууны судас нь нарийн түргэн лугшина.
- Нянгийн халууны судас нь ороож лугших бөгөөд хатуу, сул, хоосон, нарийн, хоёроор хосолсон мэт зэрэгцэж лугшина.
- Нянгийн халдвартын судас нь хатуу, ширүүн, богино лугшина.

Гадна дөрвөн улирал болон таван цул эрхтэний таван махбодыг судасны лугшилттай барилдуулан шинжлэх

1. Хаврын улиралд модон махбодтой элэгний судсанд барилдуулан шинжилнэ.
2. Зуны улиралд гал махбодтой зүрхний судсанд барилдуулан шинжилнэ.
3. Намрын улиралд төмөр махбодтой уушгины судсанд барилдуулан шинжилнэ.
4. Өвлийн улиралд усан махбодтой бөөрний судсанд барилдуулан шинжилнэ.
5. Дөрвөн улирлын завсрын хоногуудыг нэгтгэж шороо махбодтой дэлүүний судсанд барилдуулан шинжилнэ.

Сүрьеэ өвчний шээс оношлогоо

Өнгөөр шинжлэх

Сүүний зайлдас адил цайвар бол цайвар бадган юмуу эс шингэсэн өвчний шинж.

Тамирын цус адил улаан өнгөтэй бол элгэнд цус дэлгэрсэн цусний өвчний шинж. Жацын шүүсний зайлдас буюу нал эрдэнэ адил өнгөтэй бол шар усны өвчний шинж.

Хар бэх адил хар өнгөтэй эсвэл өнгийг нь тийм гэж тодорхойлох боломжгүй солонго адил өнгөтэй бол хорын өвчний шинж.

Үнэрээр шинжлэх

Цусны үнэртэй бол цусны өвчний шинж.

Шээсэнд муудсан хоолны зүйл буюу мах, замба тэргүүтэн идсэн идээний муудсан үнэр үнэртэж байвал идээ эс шингэсэн шинж.

Өгөрийн үнэртэй бол өгөр биед байгаа шинж.

Хөөсөөр шинжлэх

Хөөс нь хөх өнгөтэй жижиг, хуйларсан бол уушгинд бадган оршсон шинж.

Сэрчигнэх дуу гарч байвал нян байгаа шинж.

Хөөсны өнгө нь улаан байвал цусны өвчин буюу цус хямарсан өвчний шинж.

Хөөсны өнгө нь солонго адил элдэв өнгөтэй бол найруулсан хор зэрэг хорын өвчний шинж.

Язмагаар шинжлэх

Язмаг нь үүл адил буюу цайвар хөх, бага зэрэг улаан, хар туяатай, үзүүр нь гонзгойрч бүрхэж тогтвол уушгины халуун өвчний шинж.

Язмаг нь элс адил бэржгэр, цайвар хөх өнгөтэй, ёроолдоо шаар адил тогтож байвал бөөрний өвчний шинж.

Язмаг нь шээсний дээгүүр тогтож байвал уушги, зүрх тэргүүтэй биеийн дээд хэсэгт өвчин байгаа шинж.

Язмаг нь шээсний доор буюу савны ёроолоор байвал өвчин нь бөөр бэлхүүс, гэдэс, олгой, давсаг зэрэг биеийн доод хэсэгт байгаа шинж.

Язмаг нь шээсний дунд хэсгээр тогтож байвал элэг, дэлүү зэрэг биеийн дунд хэсэгт байгаагийн шинж.

Хэлийг шинжлэх

Хэлний өнгө улаан, зөөлөн, чийглэг, эелдэг бол өвчингүйн шинж

Хий өвчин

- Хэлний өнгө, улаан, ширүүн, хатаж хагарвал хийн өвчний шинж.
- Хэл нь хатвал гадна халуун хийгээр үлээгдсэн өвчний шинж
- Хэл нь хатвал гадна халуун хийгээр үлээгдсэний шинж
- Хэл нь хуурай, хар өнгөтэй бол хий, халуун аль аль нь байгаа шинж
- Хэл нь улаан өнгөтэй, хуурай, ширүүн бол хий нь барагдаагүй, халуун үгүйн шинж
- Хэлний өнгө нь шар, хуурай, хөшүүн бол хий, шар хавсарсан шинж
- Хэлний өнгө нь цайвар, хуурай, хөшүүн бол бадган, хийтэй халууны шинж
- Хэлний өнгө нь цайвар, нимгэн, өнгөгүй бол халуун сарнисан буюу булингартсан шинж

Шар өвчин

- Цайвар шаргал зузаан өнгөртэй бол шар өвчний шинж
- Хэлэнд шар оршвол хэлний өнгө шарлана.
- Хэлний доор шарласан бол шар өвчний шинж
- Хэлний үзүүр дээш эргэж, хуурайшиж нарийн болвол хийнээс халууны хувь их нь өвчний шинж
- Зүрхэнд шар оршвол гарцаагүй илрэх шинж нь хэлний өнгө шарлана.
- Дэлүүнд шар оршвол хэлний өнгө хөх алаг юм уу шар алаг болно.
- Хэлэнд шар оршвол хэлний өнгө шарлана. Ямар ч амттай юм идсэн гашуун амтагдана.
- Шингээгч шар өвчинд хувирсан шинж нь хэлний өнгө шарлана.

Бадган өвчин

- Хэлний өнгө нь цайвар, өнгөгүй, зөөлөн бол бадган өвчний шинж
- Бадган арильдсан үед хэл, буйлны өнгө гайрна.
- Хэлийг өөх бүрхсэн мэт байвал ходоод, элгэнд цайвар бадган дэлгэрсэн шинж

Ялгавартайд сүрьеэ өвчний үед

- Ходоод, элгний борын үед хэлний өнгө нь бор, хагарна
- Хэлний хоёр захаар харлаж байвал бөөрөнд өвчин байгаа шинж
- Уруул хагархай, цайрах, өнгө нь хөх, хар алаг болох, цэврүүтэх, шарх гарах зэрэг шинж илэрвэл дэлүү, ходоодонд өвчин байгаа нь шинж

Нүүр царайг шинжлэх

- Царайны өнгө хөхөлбөр, харласан бол хийн өвчний шинж
- Шар бол шар өвчний шинж
- Цайвар бол бадган юм уу цайвар хавангийн шинж
- Царайны өнгө дорой бол уушгины архаг өвчний шинж
- Царайны өнгө улаан, бор бол муу цус дэлгэрсэн шинж
- Сэвх тогтвол ходоод, дэлүүний өвчин юм уу умайн өвчний шинж

Цул сав эрхтэн мэдрэхүйн эрхтний шүтэлцээ

- Хамар бор хар өнгөтэй, битүүрч хаагдах зэрэг шинж гарвал уушиг, олгойнд өвчин байгаа шинж.
- Нүд улайх, нойтноор улингартах, нүд шарлах, нулимс ихээр гарах зэрэг шинж илэрвэл элэг, цөсөнд өвчин байгаа шинж.

- Уруул хагарах, цайрах, өнгө нь хөх хар алаг болох, цэврүүтэн шарх гарах зэрэг шинж илэрвэл дэлүү, ходоодонд өвчин байгаагийн шинж.
- Чих дүлийрэх, хатгуулах, идээ, цус гарах, дүнгэнэх зэрэг шинж баруун чихэнд илэрвэл баруун бөөр, давсаганд, зүүн чихэнд илэрвэл зүүн бөөр самс-д өвчин байгаагийн шинж.

Таван эрхтэний ургах орон

- Нүд нь элэг цөстэй махбодийн эрхээр барилддаг тул хэрэв элэг, цөсөнд хий, шар, бадганы бэлэг чанар дүр урвахад нүдний харах мэдрэхүйн үйл ажиллагаа доройтно.
- Чих нь баруун, зүүн бөөр, давсаг, самстай махбодийн эрхээр барилддаг тул эдгээр эрхтэнд хий, шар, бадганы бэлэг чанар дүр урвахад чихний сонсох мэдрэхүйд эмгэг өөрчлөлт илэрнэ.
- Хамар нь уушги, бүдүүн гэдэстэй махбодын эрхээр барилддаг тул эдгээр эрхтэнд хий, шар, бадганы бэлэг чанар дүр урвахад хамрын үнэрэх мэдрэхүйд эмгэг өөрчлөлт илэрдэг.
- Хэл нь зүрх, нарийн гэдэстэй махбодийн эрхээр барилддаг тул хэрэв зүрх, нарийн гэдсэнд хий, шар, балганы бэлэг чанар дүр урвахад хэлний амтлах мэдрэхүйн үйл ажиллагаа доройтно.
- Хий махбодоос хүрэлцэх мэдрэхүй үүснэ. Шар хямрахад арьс загатнана. Бадган аригдсанаар биеийн гадна, дотор хоёууланд нь илч үгүй хүйтэн болно.

Цэр шинжлэх

Хий өвчин

- » Цэр нь цайвар, сэвсгэр, хөөсөрхөг, хөх, хар өнгөтэй бол хий өвчний шинж.
- » Үдэш, үүрээр ханиаж, нүүр сэлхэрч, цэр ховхрохдоо бэрх, гарсан цэр нь хөөсөрхөг бол уушгины хий өвчний шинж.

Шар өвчин

- » Уушгинд шар оршвол нус, цэрний өнгө шарлана.

Бадган өвчин

- » Сальсархаг, хөхөвтөр, ногоовтор бол бадган өвчний шинж.
- » Уушгинд бадган буувал унжралдсан хөх, ногоон сальс гарна. Маш их ханиана.
- » Элгэнд бадган буувал амнаас хөх шүлс гарна.

Бадган бор

- » Цэр нь цустай бор гарвал бор сарнисан шинж.
- » Цэр нь өгөртэй, хөөс нь загасны нүд адил бол уушгинд өгөр байгаа шинж
- » Бадган бор тархсан уед цустай бор өнгийн цэрээр ханиана.
- » Бадган бор уушгинд тархвал цээж халуун оргин хүндэрч, цустай бор цэр үргэлжид гарна.

Дэлгэрсэн халуун

- » Цэрэнд давс амтагдах юмуу цустай холилдсон бол уушгины халууны шинж.

Хоосон халуун

- » Хийн хоосон халуун дэлгэрсэн үед цэрний өнгө улаан, шар, утааны шүүс адил олон удаан ханиалгана, амьсгал богино, цээжээр хүчтэй хаттуулна.

Булингартсан халуун

- » Уушгинд булингартсан халуун буувал ханиахад идээ, цус гарна.

Сүрьеэ өвчний үед хийгдэх шинжилгээ

- » Өсгөвөр, эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ (Эмчилгээний эхэнд болон эмчилгээний явцад сөрөгт шилжээгүй, горим солих тохиолдолд)
- » Цэрний шинжилгээ
- » Цээжний рентген шинжилгээ
- » Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
- » Биохимийн шинжилгээ (Элэгний үйл ажиллагаа, креатинин, кали зэргийг үзсэн байна.)
- » Шээсний ерөнхий шинжилгээ
- » Бамбай булчирхайн дааврын шинжилгээ
- » Хараа зүйн үзлэгийн дүгнэлт
- » Зүрхний цахилгаан бичлэг
- » Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд жирэмснийг тодорхойлох сорил.

СҮРЬЕЭ ӨВЧНИЙ ЭМЧИЛГЭЭ

Эмийн эмчилгээ

Сүрьеэ өвчний эхний шатанд **жэдтан 4** танг өгнө.

Арүр 8 эмийг удаан хугацаанд хэрэглэж болно.

Таггэм бүх төрлийн сүрьеэд хэрэглэнэ.

Элэгний сүрьеэд **лиш 5**-ийн тан өгнө.

Арүр 5

Тус эрдэм : Сүрьеэ өвчинд өвчний цус хийгээд тамирын цус ялгаж үйлдэнэ.

Шүтэх арга : Сонсох нэгэнтээ нижгээд хувийг шүтүүлнэ

Бамбо 3

Тус эрдэм : Сүрьеэ өгөр ирүүлж боловсруулж үйлдэнэ.

Шүтэх арга : Сонсох нэгэнтээ нижгээд түрхлэгийг шүтүүлнэ.

Домти 5

Тус эрдэм : Сүрьеэ өвчин өгөрийг хатаана.

Шүтэх арга : Сонсох нэгэнтээ шарх дотор

Басамын тосон эм

Тус эрдэм : Сүрьеэ шарх хатааж үйлдэнэ.

Шүтэх арга : Сонсох нэгэнтээ нижгээд хувийг шүтүүлнэ.

Заслын эмчилгээ

Дэвтээлэг засал ерөнхий үйлдэх арга нь усан дэвтээлэг ба ороох дэвтээлэг 2.

Усан дэвтээлэг нь нийтийн үйлээр өөрөө бүтсэн халуун рашаанд орвоос гэмтсэн халуун, хорын халуун хуучирсан, сарнисан, шунасан, чингаа, хуучин шарх, сүрьеэ, судлын өвчин, хөшиж атирах, бөгтийх, мах хатсаныг хатингаршсанг оруулна.

Тэр нь бүтэхгүй бол таван рашааны ууран дэвтээлэг, халуун рашаанд оруулах урьд мэт бүтээ.

Хануур засал

Хануур засал нь УАУ-ны засал эмчилгээнүүдийн дээд бөгөөд халуун өвчнийг голлон засах сэрүүн ерөндөг гэгддэг. Хануур хэмээх нь биеийн ханах судсыг хатгаж ханаснаар өвчний цусыг гадагш гаргадаг засал юм. **ᠠᠨᠠᠭᠤᠨ** хэмээх утга нь **ᠰᠤᠭᠤᠨ** буюу хатгах, нүхлэх цоолох гэсэн утгатай үг. **ᠠᠨᠠᠭᠤᠨ** хэмээх нь **ᠠᠨᠠᠭᠤᠨ** хэмээхтэй

утга нэг бөгөөд ^᠒ гэдэг нь хануурын багажаар цул савын ханах бэлчрийн дээр хатгаж өвчний цусыг гадаглуулах мөр буюу ам гаргах гэсэн утгатай юм. Хануурын гарын авлага нь голчлон цусны өвчинд тустай бөгөөд ^{᠑᠓} ^᠔ ^᠕-д өвчнийг ялгаж цусыг гадаглуулах нь хануурын увидах болно хэмээсэн байна.

Халуун өвчний суурь нь цус шар 2-оор үүсгэгддэг бөгөөд арьсанд тархах, судсанд сарних, маханд дэлгэрэх, ясанд шунах, цулд буух саванд унах, цусанд сарних, усан хаван, хямарсан, хатгалгаа, хижиг өвчин, боловсорсон, дэлгэрсэн хүнд өвчнүүд бүгд цусаар үүсгэгддэг бөгөөд цус үгүй бол өвчин гарахгүй тул хануур нь заслын дээд болно. Эм засал бусдаар үл эмчлэгдсэн өвчнийг хануураар эмчилж чадна.

Ханаж болох өвчний суурь: Гэмтсэн ба хямарсан халууны өвчин, бэтгэ, шарх, тулай, сүрьеэ, гал намс, шар усны өвчин, уяман, өвчин тэргүүтэй халуун цус шараас болсон өвчин 404 байна.

Ханаж үл болох өвчний суурь: Адтай, тамир барагдсан, жирэмсэн болон төрсний дараа, цайвар хаван, их архаг барагдсан, галын илч доройтсон тэргүүтэй бадган цайвар, хийнээс болсон өвчин бүгдэд хануурыг хориглоно.

- Мөн 16 нас хүрээгүй нялхас болон 70-аас дээш насны хөгшидөд хануурыг хийхгүйгээс гадна арилгах таван үйлийн өмнө болон дараа нь хануурыг хийхгүй гэсэн байна.

Хануурт вашага 5-ийн зааврын дагуу өгч, хүний нас, өвчний явц, онцлогийг тодруулан шаардлагатай үед ханах заслыг хийнэ.

Ханаж болохгүй биеийн бэлчир орон

- Мах, булчирхай, судасны бэрх аньс, судасны зангилааны дээр, сүлд орших газар, лусын язгуур буулттай өдөр ханаж болохгүй.

Сүлд орших газар

- Сүлд орших орныг сар, улирал, жил, суудлаар нь тооцон гаргаж болно.

Сарын сүлд орших орон:

- Хулгана гахай жилтэй хүнд өвлийн дунд сард үл ханах ба Үхэр хонь жилтэнд болно.
- Зун Бар жилтэн болохгүй бөгөөд луу жилтэн өвлийн эцэст болохгүй.

- Туулай могой зуны сүүлд болхгүй ба хавар морь жилтэнд ханахгүй. Мич жилтэн зуны дунд сард, нохой жилтэн намрын сүүл сард тэвчинэ.

Сүлд орших орныг өдрөөр нь шинжэлвэл:

- Хүний сүлд өдөр бүр өөр өөрийн эрхтэнд байрладаг тул тэр эрхтнийг энхрийлэн үзэж, үл хөндөнө.

Сар бүрийн	Эрхтний нэр	Сар бүрийн	Эрхтний нэр
1	Хөлийн эрхий хуруу	16	Цох
2	Хөлийн өлмий	17	Хүзүү
3	Хонгоны булчин	18	Алга
4	Бэлхүүс	19	Гарын бүгүй
5	Тахим	20	Дал мөр
6	Гүя	21	Хавирга
7	Сүүж	22	Бөөр
8	Бөөр	23	Сүүж
9	Хавирга	24	Гүяны зураа
10	Мөр	25	Тахим
11	Гарын хуруу	26	Өвдөг
12	Алга	27	Хонгоны булчин
13	Хоолой	28	Шагай
14	Чих	29	Хянгар шилбэ
15	Бүх бие	30	Бүх бие

Ханах аргын бэлтгэл: Хануур хийлгэх өвчтөний биеийг бүлээцүүлж, хүний хөлөөс тусгаарлан, боолтыг бэлдэн, хануурын хутга багаж, цэвэрлэгээний материал, хөвөн бент, лент зэрэг эмч өөрт хэрэг болох зүйлсийг ойр бэлтгэж тавина.

Хануурын гэм: Хануур хийж буй эмчийн ур чадвар бодь сэтгэл дутсанаар махны аньсыг гэмтээх, бүлх шөрмөсийг тасдах мах арьс судасны аньсыг хатгах, лугших судсыг тасдах тэргүүтэй эмчийн гар дайсанд үйлдэж өвчтөний гар хөл татаж хумин тэргүүтэй гэм гарахаас өгсүүлээд өвчтөнийг алах хүртэл гэм гарах тул хануур хийхдээ ихэд хянамгайлах хэрэгтэй.

Сүрьеэгийн үед ханах бэлчирүүд:

Мөрний судас- རྩུང་ཅ

Боох арга: Гарын мөрний судсыг хонин сүүл булчингийн догуур боолтоор ороож бооно.

Өвчний заалт: цээжээр хатгуулах, уушгины халуунаар толгой өвдөх, амьсгал давхцах, уушгинд цус дэлгэрч тархах, баруун зүүн талаар хатгах.

Атгаалын гадар судас- རྩུང་ཅ

Боох арга: Ханах орноос дээш гурван хурууд бооно.


Өвчний заалт: архаг ханиад, уушгины халуунаар цээж хатгуулах, цээж хүндрэх, хавирга сүвээгээр хатгуулах, цусан хатгалга, өгөр цустай ханиах.

Элэгний судас- རྩུང་ཅ

Өвчний заалт: элэгний цус шарын халуун, муу цусны гэмээр үүссэн элэгний өвчин, ухаан будангуйрах, цусаар элэг бүдүүрэх, элэгний цус ходоодонд цалгисан гэдэсний хатгалга, элэг гэмтсэнээс болсон нүдний улингар өвчин, түүш зажлуур эвэршээж хатгуулах, хавирга сүвээгээр хатгуулах, өрц өвдөх, хороор элэг бүдүүрэх, элэгний бадган бор зэрэг өвчинд тустай.

Сринлаг жавза- རྩུང་ཅ

Заалт: ходоод, дэлүү, бөөрний өвчин, халуунаар хөөж дүүрэх, ходоодны халуун гэдэсний хатгалга, далны хажуу хатгах, атгаалаа өргөж үл дийлэх, гарын мэдрэл сульдалд. Дэлүүний халуун өвчинд зүүн гарынхыг нь ханавал сайн.



Хануур эмчилгээний үед цусыг шинжлэх:

Хануурын цусны шинж нь ханах үед судасны шархнаас цус хүчтэй бөгөөд шингэн, шар, муухай үнэртэй хүүс ихтэй их хэмжээтэй, сарьсан багваахайн нуруу адил цагаан алаг юмуу цагаан хөөстэй, цусны мөн чанар нь сальстай, наалдамхай, өгөр шар сэлтийн өрөм тогтсон байвал өвчний цус мөн. Түүгээр өвчний эвэршээлийг дарах тус ихтэй өвчин хялбар арилах мөн.

Энэ нь өвчний цус тамирын цус холилдсоны шинж бөгөөд цусны дээр улаан хар зураастай гарвал хануурыг даруйд нь болих хэрэгтэй ба 3-үрийн тан өгсний дараа дахин ханавал зохино. Түүнчлэн цусны дээр өгөр шартай өрөм тогтвол дахин бага зэрэг ханах бөгөөд хансны дараа биеийн тамирыг тэтгэ. Хануурын цус улаан өтгөн гарвал өвчинд туслах нь бага ч эдгэхдээ бэрх өвчинд бага зэрэг хана.

Төөнүүр эмчилгээ

Өвчтөний биеийн байдал, өвчний явцаас хамаарч шаардлагатай тохиолдолд эмчийн заавраар тодорхой цэгт төөнүүр эмчилгээг хэрэглэж болно.

3.Сүрьеэгийн хүндрэл, эмийн гаж нөлөөг бууруулах эм эмчилгээ

Аливаа эмчилгээ нь чиглэсэн эрхтэн системд тусалдаг боловч эмийн гаж нөлөөллөөс болж бусад эрхтэн системийн үйл ажиллагааг аривдуулах, барагдуулах, буруутуулж хямруулах асуудал гардаг тул эмийн гаж нөлөөтэй эмчлүүлэгсэд эдгээр асуудлыг чухалчилан авч үзэх шаардлагатай.

Эмийн гаж нөлөө хордлогын үед хий, шар, бадганы онол, эс шингэх, халуун нян, тунгалаг цөвийн асуудал их архаг, бадган борын өвчин, хор, хорхой, шар ус, эмийн тохирох, эс тохирох, буцаж гүйх 12, амийг таслах 9 өвчин зэрэг онолын асуудлуудыг хамтад нь судалсны үндсэн дээр оношлох, эмчлэх асуудлуудыг шийдвэрлэнэ.

Гүйх мөр					
Гэм	Биеийн тамир	Хир	Эрхтэн	Цул	Сав
Хий	Яс	Шар үс	Чих	Зүрх	Олгой
Шар	Цус	Хөлс	Нүд	Элэг	Нарийн гэдэс
Бадган	Тунгалаг, мах, өөх	Өтгөн, Шингэн	Хэл	Уушиг, дэлүү, бөөр	Ходоод, давсаг


№	Амь таслах 9 өвчин	
1	Амьдруулагч 3 барагдах	Нас, үйл, буян
2	Махбодь дайсанд буух	Халуун, хүйтэн 2 нэг цагт учирсанаар ерөндөг үл авах
3	Найрлага ижилсэх	Халуун, хүйтэн өвчинд нөхөр болох ижил идээ, явдал мөр,эм заслыг шүтэх
4	Аньсанд буух	Бэрх аньсанд мэс тусах
5	Цагаас хэтэрсэн хийн өвчин амин шүтээнийг таслах	Амин шүтээн болох Вүма-н /хийн судал/ үргэлжлэл тасрах
6	Халуун даваанаас хэтрэх	Халуун өвчин засах цагаасаа хэтрэх
7	Хүйтэн ёроолдоо живсэн	Хүйтэн өвчин засах цагаасаа хэтрэх
8	Тамираар үл чадах	Өвчин нь засах цагаасаа хэтрээгүй ч биеийн тамираар эм заслыг үл дийлэх
9	Тийн хөнөөгдөх	Бүднэрийн ад зохисгүйгээр тийн хөнөөгдсөнөөр сүлд, насыг булаах

Эмийн гаж нөлөөний үед хүний өвчний явц, биеийн дархлаа, бодисын солилцооны үйл ажиллагааг сайтар мэдэж шинжилсэний үндсэн дээр эм, заслын эмчилгээнүүдийг мэргэжлийн эмч шийдвэрлэн гүйцэтгэнэ.

Тухайлбал: Данманайжог, Шижид6, Гүргүм7, Мүгвоюлжал, Сэрдог18, Сожид. Эмийн гаж нөлөө хордлогыг тайлах тусгай эм

тангуудыг өвчтөний биеийн байдал, өвчний явц, хордлого, гаж нөлөөний их багад тохируулан эмийн гаж нөлөөг бууруулдаг эм тангуудыг сонгож өгөх нь зүйтэй.

1. Хорын язгуур	
2. Хор биед орох ёс	
3. Шинж тэмдэг /Хорыг бодитой танин барих/	
4. Эмчилгээ	
5. Бурууг дарах	
6. Сүүлийг таслах	



Эмийн гаж нөлөө илэрсэн хүмүүсийг эмчлэхэд идээ унд, явдал мөрийн зөвлөгөөг сайтар өгч хамтран ажиллах нь чухал юм.

